

“АДУУНЧУЛУУН” ХК-ИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017.03.10

Илтгэгч захирал Б.Шатар

“Адуунчулуун” ХК 2016 онд хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн, ололт амжилтынхаа талаар тайлагнаж байна.

Манай компаний хамт олон 2016 онд аймаг орон нутгийн хэрэглэгчдийг нүүрсээр тасалдалгүй хангах үндсэн үүргээ биелүүлж ажилласан.

Нэг. Үндсэн үйлдвэрлэл

Адуунчулууны нүүрсний ордод 2016 оны уулын ажлын батлагдсан төлөвлөгөөгөөр нүүрс 500.0 мян.тн олборлохоос 568.9 мян.тн буюу 113,8.%, хөрс 1400.0 мян.м³ хуулахаас 1007.1 мян.м³ буюу 71,9 % биелэж.төлөвлөснөөс нүүрс 68.9 мян.тн-р өсч, хөрс 392,9 мян.м³-ээр буурсан байна.

2015 онтой харьцуулбал нүүрс олборлолт биет хэмжээгээр 99.4 мян.тн-р, хөрс хуулалт биет хэмжээгээр 78.6 мян.м³-р тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Үзүүлэлт	Х/нэгжж	2015	2016		
			төл	гүйц	зөрүү
Нүүрс олборлолт	Мян.тн	469.5	500.0	568.9	68.9
“ДБЭХС” ХК	Мян.тн	402.2	430.0	487.6	57.6
Ахуй	Мян.тн	67.3	70.0	81.3	11.3
Хөрс хуулалт	Мян.м ³	928.5	1400.0	1007.1	-392.9
Уулын цул	Мян.м ³	1323.0	1820.2	1485.2	-335.0

“ДБЭХС” ТӨХК-д гэрээний дагуу 430.0 мян.тн нүүрс нийлүүлэхээс 487.6 мян.тн-ыг нийлүүлж төлөвлөснөөс 57.6 мян.тн-р, ахуйн хэрэглэгчдэд төлөвлөсний дагуу 70.0 мян.тн нүүрс нийлүүлэхээс 81.3 мян.тн-ыг нийлүүлж төлөвлөснөөс 11.3 мян.тн-р тус тус өссөн.


Нийт олборлолтын 85.7%-ийг “ДБЭХС” ХК-д, 14.3%-ийг айл өрх, ААНэгж байгууллагад борлуулсан.

2010-2016 он хүртэлх нүүрс олборлолтын хэмжээг доорх графикт дүрсэлж харуулав. Графикаас харвал нүүрс олборлолтын хэмжээ 2010-2016 он хүртэл өссөн үзүүлэлт харагдаж байна.

Үүнд “ДБЭХС” ТӨХК-ийн хэрэглээ 2011, 2015 оноос бусад жилүүдэд өссөн, харин айл өрх, ААНэгжүүдийн хэрэглээ хэлбэлзэлтэй харагдаж байна

Уулын цулын үзүүлэлт өнгөрсөн онд 1323.0 мян.м³, төлөвлөгөөгөөр 1820.2


Нүүрс олборлолт 2010-2016 он /мян.тн/



мян.м³ байсан бол тайлант хугацаанд 1485.2 мян.м³ гарч өнгөрсөн оноос 162.2 мян.м³-р өсч, төлөвлөснөөс 335.0 мян.м³-р буурсан.

2016 оны нүүрс олборлолтын ажлыг 1 дүгээр сарын 04-ны өдрөөс 12 дугаар сарын 29-ыг хүртэл 239 хоногийн хугацаанд нүүрсний 3 түвшингээс ЭКГ-4,6Б маркийн №986, ЭКГ-5А маркийн №12273, №10823 экскаваторуудаар ачилтыг хийж ирсэн.

2016 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар: Авахад бэлэн 180,0 мянган тн нүүрсний нөөцтэй, нээгдсэн 250,0 мянган тн нүүрсний нөөцтөйгээр шилжиж байна.



Нүүрсний 730-р түвшингийн таазны цэвэрлэгээг, 740 түвшингийн хөрс хуулалтын ажлын 50%-ийг хийж гүйцэтгүүлсний дараа буюу хөрсний тээвэрлэлтийг ажлын бус зүүн бортоор явуулж эхэлснээс хойш 9 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн түвшингийн баруун талаас нь Т-130 маркийн №22, 23 бульдозеруудаар сажыг түрж, овоолон дугуйт ачигчаар автосамосвалуудад ачиж хөрсний овоолгод буулгах, мөн 730 дугаар түвшингийн дээд ирмэгийн налуу хэсэгт үлдсэн 3 м-ийн өндөртэй хөрсийг гидроэкскаватороор ирмэгээс нь задгай талбай руу татаж овоолох маягаар цэвэрлэсэн ба 730 дугаар түвшингийн зүүн хойд хэсгийн таазны цэвэрлэгээг ЭКГ-5А маркийн №10982 экскаватороор ачиж 12 дугаар сарын 03-ны өдөр дуусгасан.

Нүүрсний 730 дугаар түвшингийн таазны нийт талбайн 97%-ийг цэвэрлэж, авахад бэлэн 180,0 мянган тн нүүрсний нөөцийг бүрдүүлж ажилласан.

Нүүрс олборлолтын ажлыг уулын ажлын төлөвлөлтийн зураглал, чиглэлийн дагуу явуулж, өдөр тутам нүүрсний түвшингүүдийн замуудыг GR-180 автогрейдерээр хусч, дугуйт ачигчаар замын нунтаг ачиж зайлуулах, нүүрсний догол, мөргөцөгийн ирмэгт хамгаалалтын даланг байгуулж, экскаваторын мөргөцөгт болон автомашины ачилтын талбайд дугуйт ачигчаар түрэлт хийн аюулгүй байдлыг ханган ажиллаж ирлээ.

Оны эхнээс нүүрсний 720, 710 дугаар түвшингүүдийн зүүн хойд буланд нүүрсний олборлолтын ажлыг №12273, 986 экскаваторуудыг ажлыг явуулж эхэлсэн.

Нүүрсний 710 дугаар түвшинд №986 экскаваторыг ажиллуулж, олборлолтын ажлыг баруун чиглэлд экскаваторын хагас оролын өргөнтэйгээр авч явах явцад ногоон шаврын үе давхарга таарч, шаврыг ачиж хаях, гүний усны судал таарч, экскаватор шигдэх зэрэг хүндрэл бэрхшээлтэйгээр нүүрсний түвшингийн баруун булан хүртэл олборлолтын ажлыг явуулсан.

Хөрсний дотоод овоолгын тогтворжилтгүйгээс хүйтний улиралд илүүтэйгээр 710 дугаар түвшингийн баруун урд жигүүрт догол нь доош сууж гулсаж хагарах, зам талбайд хагарал үүсч, хагаралын ан цавыг дагаж, нүүрсний халалт ууршилт бий болж, байгаа нь ашиглалтын ажилд бэрхшээл учирч байлаа.

710 дугаар түвшингийн баруун урд жигүүрийн халалт ууршилт, ногоон шаврын давхаргыг ачиж, зайлуулах ажлыг 11-р сараас эхлэн хийж 21,5 мянган м³ уулын цулыг ачиж, дотоод овоолгын 1-р ярусын хормойд булж, тэгшлэв.

Нүүрсний 710 дугаар түвшинд олборлолтыг 986 экскаватороор зүүн чиглэлд мөргөцөгнөөс 3-5 метрийн өргөнтэйгээр ахилтыг 4-р улиралд хийж дуусган уг түвшингийн зүүн урд талаас 3 метрийн гүнтэйгээр суулгаж явуулсан.

Нүүрс бутлан шигшиж ачих төхөөрөмж 10 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн 12 дугаар сарын 15 хүртэл хугацаанд ажиллаж, хэрэглэгчдэд бүхэл нүүрсийг нийлүүлж ажилласан ба бутлуурт 21591,0 тн нүүрс тээвэрлэж буулгасан байна.


2015 онд баталсан "Автосамосвалд нүүрс ачих ачилтын паспорт"-ын талаар сургалтыг экскаваторын машинч, туслах машинч нарт явуулж, уг паспортыг нүүрсний экскаваторуудын кабинд байрлуулж ажиллав.

4 дүгээр сарын 13-ны өдрөөс 11 дүгээр сарын 24-ны хүртэл 175 хоногийн хугацаанд 1007067,4 м³ хөрс хуулалтын ажил хийж гүйцэтгэлээ.

Энэ хугацаанд хөрс хуулалтын ажлыг хойд бортонд явуулж, дундажаар 30 метр ахилт хийж, хөрс хуулалтын ажлын төлөвлөгөөг 71,93%-иар биелүүлж ажилласан байна.

2016 оны хөрс хуулалтын гүйцэтгэл 2015 оны хөрс хуулалтын гүйцэтгэлээс 78612,8 м³ нэмэгдсэн хэдий ч, 2014 онтой харьцуулахад 39754,8 м³-ээр бага хөрс хуулалтын ажил гүйцэтгэсэн байна.

Сүүлийн 3 жилийн хөрс хуулалтын ажлын гүйцэтгэл:



2016 оны хөрс хуулалтын ажлыг дараах байдлаар хийж гүйцэтгэв. Үүнд:

1. 760 дугаар түвшинд хөрсний хучилт хийгдсэн талбайд хөрс хуулалтын ажлыг 10982 экскаватороор 4-р сарын 13-наас эхлүүлж уг талбайн хөрсийг 2 оролтоор авч дуусгасан.
2. Хучилтын хөрсийг хуулсны дараа баруун чиглэлд экскаваторын 2 оролоор 10982 экскаватороор хуулж, түвшингийн 60%-ийг хуулсны дараа 750 дугаар түвшин руу зүүн бортын замаар нүүлгэсэн
3. 10982 экскаваторыг 750 түвшингийн 784 экскаваторын үлдээсэн доголын араас экскаваторын 1 оролоор баруун чиглэлд хөрс хуулалтын ажлыг хийж дуусгасан.
4. 750 дугаар түвшингийн цементлэгдсэн хатуу чулуулагийн үеийг 8690 экскаватор хуулж дийлэхгүй болж, экскаваторыг хагас оролоор баруун чиглэлд ахилтыг хийлгүүлж түвшингийн баруун буланд очсоны дараа хөрсний баруун уклоноор 760 дугаар түвшин руу нүүлгэж, уг түвшингийн баруун булангаас экскаваторын 2 оролоор зүүн чиглэлд хөрс хуулалтын ажлыг хийж, түвшингийн 40% -ийг хуулсны дараа буцааж, 750 дугаар түвшин рүү нүүлгэсэн.
5. 8690 экскаватороор 750 дугаар түвшингийн баруун булангаас экскаваторын 1 оролоор зүүн чиглэлд хөрс хуулалтын ажлыг хийлгэж дуусгаснаар 750 дугаар түвшингийн хөрс хуулалтыг гүйцээж дуусгасан.
6. 740 дугаар түвшинд 784 экскаваторын ачилтын мөргөцөг ахилт хийх боломжгүй байсан тул уг экскаваторыг 730 дугаар түвшингийн баруун уклоноор нүүлгэж, улмаар нүүрсний 730 дугаар түвшингийн тээврийн замаар 680 м нүүдэл зөөврийг хийж, 740,750 дугаар хөрсний зүүн булангаар уклон гаргасан.
7. 750 дугаар түвшингийн зүүн булангаас баруун чиглэлд хөрс хуулалтын ажлыг хийж 750 дугаар түвшингийн цементлэгдсэн хатуу чулуулагийн үеийг зүүн талаас ачиж дуусгасан.
8. 784 экскаваторыг 750 дугаар түвшингийн зүүн талаас 740 дугаар түвшин руу уклон цохиж, 730 дугаар түвшингийн дээд таазан дээр гаргаж, зүүн чиглэлд хөрс хуулалтын ажлыг хийж дуусгаж, эргэж, баруун чиглэлд ахилтыг явуулж хөрс хуулалтын ажлыг хийж дуусгасан.

Хөрс тээвэрлэлтийн замын хажуу буюу хөрсний бортод энэ онд 384,0 мянган м³ хөрс тээвэрлэж, буулгасан байна.

750 дугаар түвшингийн хөрсний мөргөцөгт ачилт хийхээр баруун талаас №8690 экскаваторыг оруулж, эхлэсэн бөгөөд уг догол нь цементлэгдсэн хатуу чулуулагийн үе давхарга таарч, экскаватор чулуулагийг буталж, дийлэхгүй хөрс хуулалтын ажил зогссон тул 5 дугаар сарын 20-ноос 6 дугаар сарын 7-ны хооронд 750 дугаар түвшингийн хөрсний догол дээр СБР-160А-24 маркийн өрмийн машинаар 78 цооног өрөмдөж, 700 уртааш метр өрөмдлөгийн ажил хийж, тэсэлгээний цооногийг бэлэн болгосон.

Өрөмдлөгийн ажил хийх хугацаанд өрмийн машины башмаг тасарч ажил зогсож, “Шивээ овоо” ХК-д хүсэлт тавьж, 5 ширхэг башмак авчруулан өрөмдлөгийг үргэлжлүүлэн хийж дуусгасан.

Тэсрэх материалын агуулахад хадгалагдаж байгаа тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг ашиглан тэсэлгээний ажил явуулахаар аймгийн МХГ, тагнуул, цагдаа, онцгой байдлын газруудад албан тоотоор хандахад аймгийн МХГ-ын улсын байцаагч тэсэлгээний ажил явуулахыг хориглосон учир тэсэлгээний ажил хийгдээгүй зогссон.

“Адуунчулуун” ХК –д олгогдсон тэсэлгээний ажлын тусгай зөвшөөрөл цуцлагдсан байна. Үүнийг 2017 онд сэргээн тусгай зөвшөөрлийг дахин авах шаардлагатай байгааг анхаарч ажиллах.

Дүгнэлт: Уулын ажлын үндсэн тоноглол ЭКГ-5А экскаватор 6 ширхэг, даацын авто самосвал 24 ширхэг үндсэн тоноглолоор доорхи уулын цулын ажил гүйцэтгэжээ.

1. “ДБЭХС” ХК –д 480985 тн нүүрсийг олборлон ачиж 7,6 км зайд станцын гадаа складад тээвэрлэн хүргэж буулгасан.
2. Хөрс хуулан ачиж 1007067 м³-ыг 1,2 км зайд зөөж тээвэрлэн түрж нягтруулсан.
3. Шимт хөрс хуулж ачин 1562 м³-ыг гадна овоолгын нөхөн сэргээлтэнд тээвэрлэн тэгшилж хөрсжүүлсэн.
4. Ахуйн хэрэглэгч аж ахуйн нэгжид 2980 тн нүүрсийг ачиж тээвэрлэн гэрээгээр хүргэсэн
5. Нүүрсний үеийн таазны болон цэвэрлэгээнд 39882 м³-ыг ачиж тээвэрлэн дотоод овоолгод асгаж тэгшилж нягтруулсан
6. Вагонд ачихад 3180 тн нүүрсийг ачиж тээвэрлэн хүргэсэн.
7. Өөрийн бутлуурт 20951 тн нүүрс тээвэрлэж бутлаж ангиллан борлуулсан.
8. 2016 онд нийт 1.465032.8 м³ уулын цулыг ачиж 83150 удаагийн ачаа тээвэрлэж 239 хоногийн ажлын өдрийн 1 хоногт 348 рейсийн тээвэрлэлт хийсэн байна.

Их засвар техник зохион байгуулалтын талаар

Үндсэн тоноглол ЭКГ-5А № 982, №8690, №823, №273-ийн экскаваторуудад их засварын ажлыг 2016 оны 3-р сарын 1-нээс 4-р сарын дунд хүртэл хийсэн.

ЭКГ-4.6, №986-д урсгал засвар, СБР-160 өрмийн машин, бульдозер № 22, 23, 24-д урсгал засвар хийж ажилд гаргасан байна. Экскаваторуудын нийт ажилласан цаг 14125 байна. Үүнээс бүтээлтэй ажилласан цаг 7910 байна.

Сул зогссон цаг 6215 цаг болжээ. Уулын хэсэгт сэлбэг материалын зардалд 364.631.761 төгрөгийг 2016 онд зарцуулжээ. Технологийн үндсэн тоноглол 24 авто самосвалд ээлжит засварыг машин тус бүрээр засварчин бүрд хувиарлан хийлгэсэн байна.

Үндсэн тоноглол тус бүрээр сэлбэг материалын зардлыг тооцож 37 нэр төрлөөр 425.487.094 төгрөгийн сэлбэг материалын зардал авто засварын хэсэгт тооцоологдсон байна.

Дизель түлш 395876 литр зарцуулж үнийг дүнгээр 579.167.173 төгрөг болж 2015 оныхоос 57.915.390 төгрөгөөр буурсан байна.Тос масло 16942 литр зарцуулах үнийн дүнгээр 82.489.911 болж 2015 оныхоос 5.977,011 төгрөгөөр буурсан байна.

Авто бензин 28132 литр буюу үнийн дүнгээр 44.682.558 төгрөг болж 2015 оныхоос 6.034.014 төгрөгөөр буурсан байна.

Ус шүүрүүлэлтий насосны сорох талыг цэвэрлэж суулгах,цахилгааны тэжээлийн шугамын найдваржилт хийсэн.

Конторын барилгын халаалтын шугам схемийг шинээр сольж дуусгасан байна.Үндсэн тоноглолуудын их урсгал засварууд өөрсдөө засварладаг болсноор засварын ажлын ахиц гарсан байна.

Цаашид засварын хүмүүсийн дадлагажилт ур чадварыг дээшлүүлж, хүмүүст тусгай сургалт явуулж мэргэжлийн зэргийг дээшлүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

Байгаль орчин, ТАА

2016 онд Монгол улсын байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2003 оны 12 –р сарын 29 –ны өдрийн тушаалд заасны дагуу “ Уул уурхайн улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал ” – ын дагуу үйл ажиллагаа явууллаа. 2016 онд нөхөн сэргээлт хийсэн талбайн баруун хойд талын овоолого буюу № 2 -д овоолгыг налуулан түрэлт хийж 18 градусын налуутай болгон түрж 6,8-га техникийн болон 3.9-га биологийн нөхөн сэргээлт хийсэн. Аймгийн байгаль орчин, мэргэжлийн хяналт, усны газраас энэ жил хийсэн нөхөн сэргээлтийн ажилтай танилцаж 81%-тай үнэлгээ авч ажилласан байна.

Нийт 4 га –газарт 2,935,000 төгрөгний 140 кг олон наст ургамал тариж 70 % -тай ургасан. Энэ жил 650 ширхэг чацаргана 1,625,000 төгрөгөөр авч тарьсан нийт ургалт 80% -тай ургасан. Мөчирыг тайрч тандал хийж өсөлтын түрэгсгэх ажил хийсэн.

Нөхөн сэргээлтын ажил 81 % тай ажилласан. Баруун хойд отволын дээд хэсгийг түрж дуусгасан.

26 ширхэг нарс авч тарисан. Нийт 578000 төгрөг, Нийт нөхөн сэргээлтийн зардал 36,233,320 төгрөг болсон байна.

2016 оны эцсийн байдлаар 1702 толгой мал. Шинэ төл :

Үүнээс: Эм хурга 204 толгой

Эр хурга 212 толгой

Эр ишиг 44 толгой

Эм ишиг 21 толгой

Эр тугал 6 толгой

Эм тугал 4 толгой

Эр унага 4 толгой

Эм унага 3 толгой мал.Нийт 498 толгой мал байна.

Үүнээс: Цайны газарт 140 толгой мал

Хорогдол 61 толгой мал

Малчин Б.Пүрэвжав 22 толгой / хонь 15, ямаа 7 /

Б.Батбаяр 19 толгой / хонь 10, ямаа 9 /


Г.Ганзориг 2 толгой / хонь 2 /

Б.Нацагдорж 15 толгой / хонь 15 /

С.Баатарчулуун 3 толгой / үнээ 2, ямаа 1 / нийт 61 толгой мал .

Бусад зардал 10 толгой мал байна.

Мал /тоо толгой/	2015	2016
	1292	1702



Энэ жилийн хувьд мал өссөн хорогдол бага гарсан байна. Бүх тарилга, туулгалт цаг тухайн бүрд хийж нийт 1,440,000 төгрөгний эм тариа авсан. Нийт төлийн орлого 22,470,000 төгрөг орлогдуулсан байна.

Шинээр худалдан авсан эд хөрөнгө:

2016 онд дараах үндсэн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр худалдан авсан байна.
Үүнд: мян.төг

Д.д	Хөрөнгийн нэр	Тоо	Бүгд үнэ	Тайлбар
1	Контейннер /40 тн-н/	1	3500.0	Сэлбэгийн складын ар талд байгаа.
2	Тавилга,эд хогшил	11	9910.0	Ажилчдын албан хэрэгцээнд
3	Компьютер,бусад хэрэгсэл	92	13722.6	Камер болон түүний дагалдах хэрэгсэл,радио станц,принтер гэх мэт.
4	Ковш трактор-809 /хөх алаг/	1	37432.8	Тоосгоны хэсэгт
	ДҮН		64565.4	

Хоёр. Компаний хүний нөөц, бүтэц зохион байгуулалтын талаар:

Захирлын 2015 оны 2-р сарын 24 -ний өдрийн А/05 тоот тушаалаар удирдлага, бүтэц, орон тоог баталж нийт 62 ажлын байранд давхардсан тоогоор 150 хүний орон тоотойгоор ажилласан.

Үүнээс:

- Удирдлага -7
- Мэргэжилтэн-4
- ИТА-12

- Ажилтан-4
- Мэргэжлийн ажилтан -79
- Туслах ажилтан-20
- Үйлчилгээний ажилтан 22

Боловсролын түвшингээр авч үзвэл:

- Дээд боловсролтой -31
- Тусгай дунд-10
- Бүрэн дунд -82
- Бүрэн бус дунд -24

Ажилчдын 47,9% буюу 71 нь 35 хүртэлх насны залуучууд байна.

Сургалт:

Ажилчдын ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор экскаватор, бульдозер, дугуйт ачигчийн машинчийн сургалтанд 4 хүн, ХАБЭА сургалтанд 2 ажилтныг хамруулсан.

Хөдөлмөрийн харилцаа, зөрчил:

Монгол улсын хууль тогтоомжууд болон компаний дотоод журам, хамтын гэрээний дагуу үйл ажиллагаагаа явуулж компаний хэмжээнд шинээр ажилд орсон 14 ажилчинтай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажилд авсан.

2016 онд компаний захирлын 55 тушаал гарсан. Үүнээс 10 нь А буюу үйл ажиллагааны чиглэлтэй тушаал, 45 нь Б буюу боловсон хүчин, хүнтэй холбогдолтой тушаал гарсан байна.

Хөдөлмөрийн хууль, дотоод журам зөрчсөнөөс 38 удаагийн давтамжтай 32 хүн сахилгын зөрчил гаргасан.

Гаргасан зөрчлийг ангилвал:

- АА-ы дүрэм баримтлаагүй осол гаргасан - 1
- Ажил тасалсан - 11
- Ажлын байранд архи уусан, ажилдаа согтуу ирсэн - 6
- Ажлын хариуцлага алдсан - 12
- Ажлын байранд хулгай хийсэн, хулгай хийхийг завдсан – 0

Дээрхи зөрчлүүдэд:

- Сануулах – 8 хүн
- 1 сарын цалин 20% бууруулах – 10 хүн
- 2 сарын цалин 20% бууруулах – 5 хүн
- 3 сарын цалин 20% бууруулах – 5 хүн

- Мэргэжлийн зэргийг 3 сар 1 шатлалаар бууруулах-1 хүн
- Ажлаас чөлөөлөх - 6 хүн

Шагнал, урамшуулал:

Улс, аймаг, орон нутгийн хэмжээнд шагнал урамшуулалд 6 ажилчин, 3 ахмадыг тодорхойлсон.

- Тэргүүний уурхайчин цол тэмдэг – 2 ажилчин, 3 ахмад, нийт 5 хүн
- Яамны жуух бичиг – 2 ажилчин
- Чойбалсан хотын Тэргүүний ажилтан – 1 ажилчин
- Чойбалсан хотын Засаг даргын жуух бичиг -1 ажилчин

Гурав. ХАБЭА-н талаар

Тус компани 2016 онд ХАБЭА-д зориулан урьдчилсан дүнгээр 90.9 сая.төгрөг зарцуулсан байна.

1. Галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрууд дахь гал унтраагуулуудад 2016 оны 03-р сард шалгалт хийж гурван хэсэг болон захиргаа аж ахуйд нийт 30 ш галын хор олгосон байна. Гэвч тайлант оны 04 сарын 01 болон 05 сарын 28-ний өдрүүдэд уурхайн нүүрсэнд гал түймэр гарч нийлбэр дүнгээр 62.3 сая төгрөгийн хохирол учирсныг актаар тогтоов. Мөн 10-р сард галын бэлэн байдлын үзлэг явуулж шаардлагатай ажлын байруудад нөхөн гал хор АВС-4 –г 29 ш галын хор, галын гидрантуудад галын шланг хошууг угсран 11ш бэлэн байдалд оруулсан байна.
2. Компанийн аюулгүй ажиллагааны хяналтыг сайжруулах, баримтжуулах зорилгоор уурхайн үндсэн хэсгүүдэд ХАБЭА-н I, II шатны хяналтын дэвтэр хөтлөн үр дүнг тооцож ажиллах явдал хангалттай хэмжээнд хүрээгүй байна.
3. Компанийн хэмжээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн системийг хэрэгжүүлэх, ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх ажлууд хийгдээгүй.
4. Уурхайн орчин, байгаль орчны бохирдолтын хяналт шинжилгээг хоёр удаа хийлгэж 2.2 сая төг зарцуулан Аймгийн УЦУОША – аар гүйцэтгүүлсэн байна.

ХАБЭА зааварчлага, сургалт, эрүүл мэндийн үзлэг, осол

1. ХАБЭА-н сургалтыг 2016 оны 02 дугаар сарын 27, 29 өдрүүдэд батлагдсан хөтөлбөрийн дагуу явуулахад 138 ажилтан бүртгэлтэйгээс 104 нь ирж 75.36% тай оролцов. Тус компанийн краны аюулгүй ажиллагаа хариуцагч , сумт болон гүүрэн краны оператор, оосорлогч дохиочны үнэмлэх сунгуулах, давтан болон эхлэн суралцах нийт 18 ажилтныг сургалтад хамруулсан. Цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцаж ажилладаг ажилтныг сургалтад хамруулан шалгалт авч ажиллах эрхийн зөвшөөрөл олгосон. Сургалтын шууд зардал 2.27 сая төг зарцуулжээ.
2. 2016 онд ХАБЭА урьдчилсан зааварчлагыг 67 иргэн, ажилтанд , шинээр ажилд орсон 16 хүнд өгчээ..
3. Компанийн хэмжээнд ХАБЭА ээлжит давтан зааварчлага хэсгүүд улирал бүрд өгч ажилласан байна.
4. Уурхайн тоосжилт ихтэй орчинд ажиллагч ажилтнууд амьсгал хамгаалах хэрэгслийг тогтмол хэрэглэх явдал хэвшил болоогүй. Зам усалгаа жигд бусаас тоосжилт дэгдэж зарим тохиолдолд ажилтнууд гомдол, саналаа ХАБЭА-н ажилтанд мэдүүлж байв.
5. Карьерын замын уулзвар, нүүрсний түвшингүүдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад анхааруулах болон заах тэмдэг, тэмдэглээг уулын хэсэгтэй хамтран зохих газруудад тавьж, экскаваторуудад дуут дохионы санамжийг харагдахуйцаар байршуулсан. Тэмдэг тэмдэглэгээнд 3.927.0 мянган төгрөг зарцуулсан байна.
6. Компанийн ажилтнуудаас ажил мэргэжлийн шалгалтыг 2016 оны 03-р сард авахад үндсэн хэсгүүдийн 106 ажилтнаас 85 ажилтан орж , ажил мэргэжлийн шалгалтанд

хамрагдагсдын 52.8 хувь нь хангалттай дүн үзүүлэв. Шалгалтанд хамрагдаагүй болон хангалтгүй шалгуулсан ажилтнуудаас давтан шалгалтыг 11 сарын 25-д авсан . 30 ажилтан хамрагдан тэнцжээ.

7. Хэсэг, нэгжүүд ХАБЭА-н сар бүрийн ажлын төлөвлөгөө гарган биелүүлэлт жигд биш , бүрэн бус хэрэгжиж байна. Компанийн ХАБЭА инженерийн зүгээс аюулгүй ажиллагааны зөвлөмжийг ЦСХэсэгт 2016 оны 02 сарын 04 нд нэг удаа өгсөн, мөн албан шаардлагыг уулын хэсэгт- 2, автозавсар хэсэгт -2, цахилгаан сантехникийн хэсэгт-2 удаа тус тус өгсөн ч хариу ирүүлээгүй. ХАБЭА-н ажилд хандах хандлагыг сайжруулах зорилгоор хөдөлмөрийн хуулийн дагуу зохих хариуцлагыг дээрхи хэсгийн дарга нарт ногдуулсан.

Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах ажлын хүрээнд

1. Нийт ажиллагсдыг эрүүлжүүлэх, өвчлөлийг бууруулах зорилгоор ажлын байранд эмчилгээ сувилгаа эм тариа хийх, анхны тусламж үзүүлэх 3 236 697 төг ариутгал устгалд 236 000 төг бүгд 4 388 697 төгрөг зарцуулжээ.
2. Ажлын байрууд дахь анхны тусламжийн 80 эмийн сангуудад 2 удаа эм, ороох материалаар нөхөн хангалт хийж дээрхи дүнгээс энэ ажилд 916.0 мянган төгрөгийн зардал гаргасан.

Үйлдвэрлэлд гарсан ослын мөрөөр авч хэрэгжүүлсэн ажил

Компанийн хэмжээнд 2016 онд үйлдвэрлэлийн осол 1 удаа гарсан. Осолд дөхсөн тохиолдол 18 бүртгэгдсэн байна.

Уурхайн нүүрс бутлуурын төхөөрөмжид 2016 оны 07 дугаар сарын 05 -ны өдөр үйлдвэрлэлийн осол гарсныг компанийн “ Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс” судлан бүртгэж ослын акт тогтоож аймгийн МХГ-ын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчаар баталгаажуулсан.

Ослын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу ослын циркулярыг гарган, нийт ажиллагсад танилцуулан ажиллаж байна.

Дөрөв. Компанийн хөрөнгийн талаар

Компанийн нийт хөрөнгө тайлант оны эцэст 10206.2 сая төгрөг болж оны эхний үлдэгдлээс 177.1 сая.төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт хөрөнгийн дүнгийн 48.06 %-ийг эргэлтийн хөрөнгийн дүн, 51.94 %-ийг эргэлтийн бус хөрөнгийн дүн эзэлж байна.

А.Эргэлтийн хөрөнгө

№	Балансын зүйл	2015.12.31	2016.12.31	Өөрчлөлт	/сая.төг/
					Нийт эргэлтийн хөрөнгийн дүнд эзлэх хувь
0	1	2	4	5	6
1	Мөнгө	900.3	967.6	67.3	19.7
2	Дансны авлага	1685.9	2575.3	889.4	52.5
3	Бусад авлага	17.8	17.6	-0.2	0.4

4	Бараа материал	1165.9	1262.8	96.9	25.7
5	Мал амьтад	59.2	82.2	23.0	1.7
	Дүн	3829.2	4905.6	1076.4	100

Эргэлтийн хөрөнгийн дүнгийн өөрчлөлтөөс харахад нийт эргэлтийн хөрөнгийн хэмжээ оны эхний үлдэгдлээс 1076.4 сая төгрөгөөр өссөн бөгөөд мөнгөний үлдэгдэл 67.3 сая төгрөгөөр, дансны авлага 889.4 сая төгрөгөөр, бараа материалын үлдэгдэл 96.9 сая төгрөгөөр, эргэлтийн сүргийн мал амьтад 23.0 сая төгрөгөөр тус тус өсч, бусад авлага дансны үлдэгдэл 0.2 сая төгрөгөөр буурсан байна.

-Эзэмшигчдийн өмчийн хувьд тайлант хугацаанд 911.2 сая төгрөгөөр нэмэгдэж, 2015 оны ноогдол ашигт 315.1 сая төгрөг олгосноор тайлант хугацааны эцэст эзэмшигчийн өмчийн дүн 9934.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч байна.

2017 онд тавих зорилт

- Нийт ажилчдынхаа дунд хувь хүний үнэлэмжийг сайжруулж тодруулан ажилласнаар тухайн хүний ур чадвар, идэвх санаачлагыг дээшлүүлэх оновчтой ажил зохиож ажиллах.
- Ажилчдынхаа дотоод нөөц бололцоог илэрүүлж авъяас чадвар, сонирхлыг хөгжүүлж сургах боломжууд гарган дэмжиж байгууллагынхаа төлөө гэсэн сэтгэл зүйг төлөвшүүлж ажиллана.